

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 08 дугаар сарын 14-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

4-14

*1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хяналтын
сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/*

**Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2024 оны 08 дугаар сарын 14-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 20 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 55.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 43 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Х.Баасанжаргал, Б.Бат-Эрдэнэ;
Тасалсан: Ж.Алдаржавхлан, Х.Баттулга, Д.Ганбат, С.Одонтуяа.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, П.Сайнзориг, О.Номинчимэг, М.Нарантуяа-Нара, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, М.Нарантуяа-Нара нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: “Хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 7
Бүгд: 12
41.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: “Хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 7
Бүгд: 12
41.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг санал хураалтыг гар өргөж явуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: “Хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 44 минут үргэлжилж, 20 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 14-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
15 цаг 43 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг эрвэ. Байнгын хорооны ирц бүрдсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг би танилцуулъя. Хуралдааны ирц 55 хувьтай байна.

Ингээд ирц Мөнхтөрийн Нарантуяа гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Пүрэвжавын Сайнзориг гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн ийм гишүүдийн ирцтэйгээр өнөөдрийн хурал эхэлж байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг ийнхүү танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр хэлэлцэх асуудал нэг л асуудал байгаа. Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголын тов тогтоох, сонсголын сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу?

Байхгүй байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголын тов тогтоох, сонсголын сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл. Байнгын хорооны тогтоолын төслийг тараачихсан байгаа. Харин би Байнгын хороонд ирүүлсэн Ж.Баярмаа гишүүн болон нийт 22 гишүүн гарын үсэг зурсан байгаа. Энэ хүсэлтийг уншиж танилцуулъя.

2024 оны 8 дугаар сарын 4-ний огноотой ийм хүсэлт байгаа. Улсын Их Хурлын хяналтын сонсгол явуулах тухай,

Монгол Улс Үндсэн хуулиараа хүмүүнлэг, энэрэнгүй нийгмийг цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болон хүний амьд явах эрхийг 16 дахь зүйлийн 1 дэх хэсгээр баталгаажуулж, хэнд ч болов эрүү шүүлт тулгаж хэрцгий хандахыг 13 дугаар хэсгээр хориглосон.

Харамсалтай нь эрхээ хязгаарлуулсан үедээ амиа алдсан иргэн аюулгүй байдлыг нь хамгаалах үүрэгтэй төрийн зарим албан хаагчийн хүнлэг бус эрүү шүүлтэд өртсөн байж болзошгүй ноцтой хэрэг саяхан гарлаа. Түр болон албадан саатуулагдаж, цагдан хоригдож буй иргэд ял эдэлж буй хоригдлууд, цэргийн алба хаагчдын амь нас, бие махбод, сэтгэл санаатай холбоотой хүний эрхийн зөрчлүүд хууль сахиулах болон батлан хамгаалах байгууллагуудад удаа дараа гарч төрийн зарим тушаалтнууд үүнд холбогдож байна. Энэ нь ХЭҮК-ын удаа дараагийн илтгэлүүдээр нотлогдож буй тул даамжирч хэвийн үзэгдэл мэт болж байгаа дээрх үйлдлийг хойшлуулиггүйгээр таслан зохих шаардлагатай болжээ.

Үүнээс гадна иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээллээр хангагдах, жагсах цуглах, 4

дэх засаглал болсон сэтгүүлчдийн эрэн сурвалжлах, хэвлэн нийтлэх эрх чөлөө чөлөө ч мөн улам хязгаарлагдсаар байна.

Иймд дээрх байгууллагууд хэвлэл мэдээллийн болон бусад салбар дахь хүний эрхийн төлөв байдал, зөрчлийн талаар олон нийтэд сонсгох шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх, ёс зүй, хариуцлагын механизмыг сайжруулах, хууль тогтоомжид нь нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг холбогдох арга хэмжээг нэн яаралтай авах шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.12, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.3 дахь хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 6.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулах хүсэлтийг дараах нэр бүхий Улсын Их Хурлын гишүүн гаргаж байгааг хүлээн авч шийдвэрлэж өгнө үү.

Хүндэтгэсэн, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа гэсэн байна. Ингээд нийт 22 гишүүн энэ дээр гарын үсэг зурсан байгаа юм.

Тэгээд энэ бол өөрөө цаг хугацаатай асуудал. Энэ хүсэлтийг гаргаснаас Дэгийн тухай хууль болон Хяналт шалгалтын тухай хуулийн дагуу 5 хоногийн дотор, ажлын 5 хоногийн дотор хэлэлцэх ёстой байгаа. Яг энэ хугацаа өнөөдөр дуусаж байгаа юм. Тийм учраас энийг бид нар өнөөдөр хуралдаад шийдэх ёстой байгаа.

Ингээд тогтоолын төслийг та бүгдэд тараасан байгаа. Би түрүүн хэлсэн. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү. Нэрсээ юугаараа өгөөрэй. Өө тийм наагуураа өгнө.

Тийм санаачлагчаасаа л асууна л даа. Яг энэ тогтоол яагаад одоо өргөн барьж байгаа процедурын асуудлаар Байнгын хорооноосоо асууж болно. Түүнээс энэний яг агуулгын талаар мэдээж санаачлагчаасаа асууна. Тийм. Одоо бид нарын яг энэ хэлэлцэх асуудал энэ, бид нар энэний агуулгыг нааш цааш угаасаа хөдөлгөх боломж байхгүй. Ерөөсөө хэлэлцэж байгаа асуудал нь тов, даргыг нь сонгож өгөөд энэ хуралдааныг явуулах нөхцөл боломжийг л хангаж өгөх тухай асуудал байгаа. Ингээд Сандаг-Очир гишүүнээр тасаллаа.

Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Зарчмын хувьд нэг юм яачихъя. Харин үг, асуулт хоёроо нэгтгэчихье тэгэх үү?

Х.Тэмүүжин: Тэгье.

Д.Цогтбаатар: Нэгтгэлээ.

Х.Тэмүүжин: Надад ер нь ингээд цаашидаа ч гэсэн ийм сонсголттой Их Хурлын ерөнхий хяналттай холбоотой юмнууд ингээд нэлээн гарах байх. Дараа дараагийнх дээр ингээд Байнгын хороо юм уу, дэд хорооны эрхлэх ингээд бүрэн бүтэн асуудлыг хөндлөнгийн сонсгол байдлаар ингэж явах нь хэр зохимжтой вэ гэдгийг жоохон ярилцах ёстой байх. Нэг.

Хоёрт нь энэ удаагийн энэ хүсэлттэй холбоотой гэхээр 2 ийм том сэдвийг 1 сонсголоор явуулах нь бас ерөөсөө зөв биш. Хууль сахиулах болон батлан хамгаалах салбарт ингээд иргэд амь насаа алдаж байгаатай холбоотой ийм асуудлыг 1 тусад нь явуулаад, энэ ард байгаа хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой хэсэг байна шүү дээ. Энийг бас тусад нь явуулах нь илүү зөв байх. Мэдээллээ авах болон асуудлаа ажил хэрэгч шийдэхэд илүү зохимжтой байх гэж харж байна. Тэгээд би бол зүгээр хэрвээ ингээд энийг өөрчилж болох хувилбар байгаа бол тогтоолын төслийг

хоёр салгаад энэ сэдвийн хэлэлцүүлэгтэй холбоотой санаачлагчтай ярилцаж тохироод хоёр салгаж, сонсгол зохион байгуулмаар байна.

Амь насаа алдсан болон хууль сахиулах цэрэгтэй холбоотой хэсэг дээр нэг тусдаа. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл буюу хэвлэн нийтлэх эрх чөлөө, сэтгүүлчтэй холбоотой асуудал дээр нэг тусдаа. Ингээд хоёр сонсгол зохион байгуулъя.

Энэ сонсгол зохион байгуулах асуудал дээр хоёр тусад нь ажлын хэсэг юм уу юу гэдэг юм тэр сонсгол зохион байгуулах хүнийг нь тусад нь гаргая гэдэг тийм юм хэлбэл яасан юм. Ийм л санал байна.

Д.Цогтбаатар: Энэ дээр яагаад ингэж гаргасныг уг нь энэ хүсэлт гаргасан хүмүүс өөрсдөө уг нь хариулах ёстой. Энд гарын үсэг зурсан бүх гишүүд Ардчилсан намын гишүүдэд маань байж байгаа. Тэгэхлээр бас дотроо уг нь зөвлөлдөх л байсан байна. Яг процедурын хувьд бидний хувьд хязгаар бидний үйл ажиллагаанд аягүй тодорхой хязгаар. Энэ хүсэлтийг гаргалаа. Энийг чинь ямар нэгэн техникийн асуудлаар зогсоодог байлгахгүйн үүднээс ерөөсөө автомат ингээд л товыг нь тогтоогоод л, даргыг нь томилж өгөөд л явуулахаас өөр зам байхгүй болчихоод байна энэ дээр бол. Түүнээс өөрийн чинь ярьж байгаа нээрээ зөв шүү. Энэ чинь талаар нэг тарсан хэлэлцүүлэг болох байхгүй юу. Хүний эрхийн төлөв байдлын тухай бид нар Хүний эрхийн Комисс дээр тэгээд Хүний эрхийн хороон дээр Женевт хэлэлцүүлэг хийх гэж л өргөн илтгэл улсаараа гаргаад явдаг шүү дээ. Энэ ерөнхий сэдвээрээ орох юм бол яг тэрийг бүтэн гаргах л юм болчихож байгаа юм. Тэгэхлээр техникийн хувьд Тэмүүжин гишүүн ээ үнэхээр бид нараас хамаарах юм байхгүй болчихоод байна.

Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Би бас Тэмүүжин гишүүнтэй ер нь төстөйдүү агуулга юм хэлэх гээд байгаа юм. Процедур баригдаж бас ийм маш ерөнхий ийм ойлгомжгүй байдлаар сонсгол зохион байгуулна гэдэг бас их өрөөсгөл байна.

Өөрөөр хэлэх юм бол одоо яг албан бичгийг дурдаж байгаа асуудал тэр сүүлд болсон ганц залуугийн амь нас эрсэдсэнтэй холбоотой зүйлүүдийг дурдаж байна. Хэвлэлийн эрх чөлөө, жагсаж цуглах гээд бас энэ бас зүйлүүд дотор нэлээн өргөн цар хүрээтэй юмнуудыг бүгдийг нь дурдаад байгаа мөртөө яг Улсын Их Хурлын энэ Байнгын хорооны тогтоол дээрээ хүний эрх чөлөөг хамгаалахтай холбоотой гээд. Тэгэхээр ерөөсөө л энэ зүйлүүд нь болж өгөхгүй байгаа юм болов уу? Тэгэхээр энийг цаашидаа зүгээр бас манай Байнгын хорооны ажлын алба энэ тэр бас анхаарчихгүй юу. Ер нь зүгээр ингээд процедурт баригдаад л ямар ч хамаагүй юм бичээд ирэхээр сонсгол зохион байгуулах ёстой юм аа гээд ингээд байвал энэ чинь өөрөө эргээд энэ үйл ажиллагааны ач холбогдол байхгүй болчих гээд байна.

Дээрээс нь эргээд энэ Байнгын хорооны эрхлэх асуудал, энэ Байнгын хорооны дотор байгаа дэд хорооны маань эрхлэх асуудлын хүрээг давхцаж ингээд, эсвэл хэвлэлийн бага хурлыг их улс төржүүлэх сэдэв болгож ийм байдлаар явбал энэ хүний эрх чөлөө дээр чинь бас ноцтой шүү дээ. Би бол одоо бас яг энэ ялангуяа бас энэ Хууль зүйн байнгын хорооны гишүүд маань мэргэжлийн байгаасай гэж хүсэж байгаа юм. Би бас Хууль зүйн сайд Алтангэрэлд ч гэсэн хэлсэн. Та ингээд жишээ нь албан тушаалтнуудын хөрөнгө орлогыг хураана аа, хууль санаачилна аа гээд явж байна лээ. Энэ тэгэхдээ болохгүй шүү. Энэ өөрөө эргээд Эрүүгийн хууль дээр байгаа зүйлийг жишээ нь улс төрийн сэдэв болгож зүгээр олон нийтэд ярьж байгаа нь энэ сүүдрийн илтгэл бичдэг хүмүүс чинь энийг чинь бичээд явуулчихдаг байхгүй Олон улсын

байгууллагад. Одоо хүртэл мөнгө угаах болон гэмт хэргээс үйлдэж олсон хөрөнгө орлогыг хураахгүй байгаа юм байна. Хууль зүйн сайд нь ийм юм яриад явж байна шүү дээ гэхэд бид хэд хамгаалахад хүртэл хүнд болдог юм.

Тэгэхээр энэ улс төржих сэдэв, өнцөг энэ бүх зүйлээ ингэж бодож яахгүй бол сүүлдээ ингээд бас тодорхой хэмжээний гишүүд яагаад л ийм ерөнхий юм биччихдэг энэ тогтоолоо өөрсдөө бас орж ирж хамгаалдаггүй. Тэгээд ийм ерөнхий юм шийдчихээд энийг бас олон нийтэд ямар байдлаар яах гээд байгаа юм. Тэгэхээр энэ дээрээ бас жоохон мэргэжлийн бас цааши цаашидаа бас сэдвийг бүдгэрүүлэхгүй үнэхээр нэг сэдвийг бас олон нийтийн анхааралд оруулж ирж бас шийдэл ярьяа аа гэж байгаа бол бас энэ дээрээ ч гэсэн яг тогтоол энэ тэр дээр бас хянаж анхаармаар байна. Энийг магадгүй яг албан бичгийг хүлээж авлаа гэхэд энийг процедурыг нь хийж өгөх ёстой байхгүй юу. Энэ бас нийтийн хяналт шалгалтын хууль дээр. Ийм ерөнхий байх юм бол тодруулна. Тодорхой ийм ерөнхий сэдэв байх юм бол энэ чинь цаг хугацаанд баригдах учраас ийм ийм сэдвүүдийг энийг санаачилж байгаа хүмүүсээс тодруулсны үндсэн дээр тов юуг зарлана аа ч гэдэг юм уу. Тэгэхээр ийм зүйлүүдийг бас цаашидаа хэдүүлээ ч гэсэн хийж анхаарах ёстой юм байна. Байнгын хорооны тогтоол дээрээ бол тэр үйл явдлыг дурдаад бараг тогтоолоо гаргамаар байна. Би бол одоо зөвхөн тэн дээр сонсох л юм байна гэж л, хяналтын сонсгол байна гэж ойлгоод байгаа. Тэгэхээр энийг тэр гишүүд нэр бүхий гишүүдээс нь.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүд маань сая хоёр үг хэлж байгаа гишүүн маань та бүгд ойлгож байгаа. Миний хувьд одоо энэ санаачилга гаргасан хүмүүсийн өмнөөс хариулаад суугаад байх чинь их хэцүү байна. Тэгэхдээ нөгөө талаасаа энэ яах аргагүй хууль зүйн аягүй чухал асуудлууд тавьж байгаа байхгүй юу.

Яагаад гэвэл энэ Үндсэн хуулийн 16 дугаар зүйл гэдэг ерөөсөө Монгол Улсад хэрэгжиж байгаа өнөөдөр хүний эрхийн бүх хуулиуд эндээс л ургааж гарч байгаа юм. Тэгээд энэний 16.1 гээд заасан юм шиг боловч үг хэлэх эрх чөлөө эд нар гээд явангуутаа энэ өөрөөр хэлбэл, цаашиа агуулгаараа аягүй задарчхаж байгаа юм. Тэгээд энийг миний эрх мэдэл энэ хязгаарлалттай байгаа учраас энэ дээр Сайнзориг гишүүн ээ би танд хариулах боломжгүй байна.

Тэгээд боловсруулах шатанд нь харин байгууллагуудаас мэдээлэл эд нар ирэхэд нь, би бол ингэж бодож байна яг үнэнийг хэлэхэд. Энэ чинь юунд хариулах вэ гээд тэртээ тэргүй асууж таарах байх л даа наашиа. Тэгэхлээр энэ эд нар дээр нь гишүүдтэйгээ ярьж байгаад л зөвлөлдөөд ийм ийм чиглэлээр гэж явцын дунд нь л ингэж өгөхгүй бол засах бол боломжгүй болчхоод байна.

Номинчимэг гишүүнд микрофон өгье. Процедурын тухайд гэвэл Сайнзориг гишүүн ээ процедурын хууль нэгэнт ингээд л ийм л процедуртай. Бид хуулийг өөрчлөөгүй байхад хууль энэ боловсронгуй биш байна аа гэж хэдүүлээ бодож өөрчилж болохгүй шүү дээ.

Ялангуяа Хууль зүйн байнгын хороо бол хууль л бол хууль. Процедурын хууль байна уу, өөр хууль байна уу бид нар яг л дагаж мөрдөхөөс өөр сонголтгүй.

Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Миний санаанууд угаасаа сая өмнө хэлсэн үг хэлсэн гишүүдтэй давхардаж байгаа учраас бас товчилчихье.

Ер нь бол ингээд харахаар бас тогтоолын төслийг харахаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой хяналтын сонсгол гээд тэгэхээр маш өргөн цар хүрээтэй тийм сонсголыг нэг өдөр хийхэд яг юун дээр фокуслах вэ, юу хийх вэ гэдэг нь тодорхойгүй учраас хэр

үр дүнтэй сонсгол болохоо гэдэг ийм асуудал байна. Тэгэхээр хэрвээ үнэхээр явуулах ёстой гээд энэ чинь манай хүний эрхтэй холбоотой асуудлыг Байнгын хороо өөрөө санаачилж яадаг. Тэгэх юм бол бид нар энэний сонсгол явуулахгүй байж болно гэж бас санал хураалт хийж болохгүй юу Дэгийн хуулиараа энэ? Энэ 119.3-д хамаарахгүй тээ Байнгын хороо? Тэгвэл ядаж, хэрвээ 9 сарын 10-нд ийм сонсгол хийх гэж байгаа бол ямар асуудлын хүрээнд юм гэдгээ нэг тодорхой болгоод арай үр дүнтэй байдлаар зохион байгуулахын тулд зөвхөн нэг даргалагч томилно гэхээсээ илүүтэйгээр ажлын хэсэг бас байгуулж болох юм байна шүү дээ. Тэгээд энэ санаачилж байгаа энэ хүмүүс маань хоорондоо яриад яг юун дээрээ фокуслах юм гэдгээ яриад энийгээ зохион байгуулалтаа хийсэн нь дээр болов уу гэж бодож байна.

Яагаад гэвэл өмнөх тодорхой нэг хэргийн талаар Хүний эрхийн дэд хороо аль хэдийн хуралдаад бас нэлээн мэдээллүүд өөрөө энэ санаачлагч маань ч гэсэн мэдээлэл өөрөө бас авчихсан байгаа байх. Тэгэхээр бид жишээ нь энэ хүн яг юу хүсэж бас яг алин дээр нь фокуслах гэж ийм хүсэлт гарсныг өөрийг нь байхгүйд шийдэж чадахгүй учраас хэрвээ заавал тов тогтоох ёстой бол ажлын хэсэг байгуулаад тэн дээрээ цар хүрээгээ бас илүү тодорхой болгож, үр ашигтай бас цагаа бид нар өнгөрөөх тал дээр анхаарсан нь дээр болов уу гэсэн саналтай байна.

Д.Цогтбаатар: Би Номинчимэг гишүүн ээ ингэж бодож байна. Сая ингээд Тэмүүжин гишүүн ч ярилаа, Сайнзориг гишүүн ч ярьсан. Ер нь бол би ингэж бодлоо. Хэдүүлээ тогтоолоо гаргачихъя. Тэгээд дараа нь энэ санаачлагчтайгаа Баярмаа гишүүнтэй би суугаад энэ хүрээ эд нарыг нь тэгээд мэдээж хуралдаан даргалагчтайгаа суугаад хүрээ эд нараа тохирч авъя. Энэ хурал энийг санаачилж байгаа гишүүн өөрөө хүрээгээ тогтоож өгөхөд өөрт нь ямар нэгэн хязгаарлалт тавиагүй

байгаад байгаа шүү дээ. Тэгэхлээр тэрийг тэд нартайгаа ярьж байгаад л өөрөө тэр юугаа зохицуулаад оруулаад ирнэ биз. Тэгээд тэнд ёстой нэг тооршиг юм хийж л өгье. Би тэгээд ажиллаад л үзье тэгэх үү? Тэгж бол би болж байна гэж бодож байна.

Нарантуяа гишүүн.

М.Нарантуяа-Нара: Энэ угаасаа давхцаж байгаа маш олон зүйлүүд байгаа. Тэрийг яриад яах вэ. Юуны түрүүнд нэгдүгээрт бид нар сая өнгөрсөн хугацаанд Хүний эрхийн дэд хороо хуралдсан. Дэд хорооны гишүүд бүгд байлцахаас гадна Баярмаа гишүүн, Цэнгүүн гишүүн, Мөнхбаясгалан, Шижир гишүүн нар орж ирж байлцсан. Тэгэхээр ялангуяа энэ 21 настай амиа алдсан хүүхдийн, залуугийн хэрэг дээр болохоор зэрэг бас ийм ярвигтай тэр хүний эрхэм, нандин чанарт халдсан ийм зүйлүүд яригдсан шүү дээ.

Дээрээс нь энэ хүрээнд бид нар холбогдох байгууллагуудад 11 асуулга бүхий тодруулга бэлтгэж ирэх ёстой зүйл ийм чиглэлүүдийг өгсөн. Тэгээд ийм зүйл ярьчхаад тэрийг ирэхээс өмнө ийм сонсгол зохион байгуулья гэсэн санаа бол яг их оновчтой юу, эс үгүй бол илүү жсоохон тийм поп чиглэл рүүгээ хандчихсан юм биш үү гэж би бол хувьдаа бодож байна.

Яагаад гэвэл эхлээд тэр холбогдогч байгууллагуудаас ямар хариу ирэх юм тэр хариултууд нь хангалтгүй ийм санагдсан тохиолдол дараагийн сонсголыг зохион байгуулсан бол зүгээр байх байсан.

Хоёрдугаарт, цэргийн асуудал бол өнгөрсөн хугацаанд саяхан шүү дээ өнгөрсөн жил байна уу маш том сонсгол зохион байгуулаад явагдсан асуудал байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр дахиж орж ирж байна.

Хоёрт бас нөгөөтээгүүр энэ хэвлэн нийтлэх 4 дэх засаглалтай

холбоотой асуудлыг энэ гурвууланг нь базаад нэг сонсгол гэвэл энэ бол маш учир дутагдалтай сонсгол болно. Тийм учраас, тэгээд дээрээс нь энэ санал гаргасан гишүүн өөрөө энэ хуралдаа бас байж, асуултдаа хариулдаг баймаар юм гэж бодож байна.

Ер нь маш түгээмэл, нийтлэг нэг удаагийн сонсголоор бүрэн шийдэгдэхээргүй асуудлуудыг нэг ийм базаад оруулаад ирчихсэн байгаа л харагдаж байна.

Д.Цогтбаатар: Санал нэг байна энэ дээр Нарантуяа-Нара гишүүнтэй. Энэ цаашидаа энийг нээрээ ингээд тал талдаа л анхаарах ёстой. Яагаад гэвэл тэр асуудал гарангуутаа тэнд нэлээн самгардаад л ерөөсөө юу гэдэг юм сэтгэлийн хөдлөлөөр нир гээд л хөдлөөд л явчихсан байгаа юм шиг харагдаж байгаа. Тэгэхдээ хүний эрхийн асуудал бол хаашаа ч яарах ёсгүй, яг барьж сууж углуургаар нь шийдэх ёстой асуудал байхгүй юу. Тэгэхгүй бол энэ дээр зүгээр ингээд юу гэдэг юм нөгөө талаасаа гүйцэд хариултаа сонсолгүйгээр муу байна гээд л зүгээр дүгнээд яваад байна гэвэл бид нар юмаа засаж чадахгүй байхгүй юу. Тэгэхлээр тэн дээр би санал нэг байна.

Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Би мөн өмнөх гишүүдтэй адилхан саналтай байна. Үндсэн хуулийн нэг бүлэг, бүхэл бүтэн бүлгийн асуудлыг нэг сонсгол хийгээд бид нар чинь өнгөрсөн 30 хэдэн жил хүний эрхийн асуудлыг яриад хангаж чадахгүй байгаа улсууд нэг сонсгол хийгээд нэг сонсголын үр дүнгээр ингээд хүний эрхийг хангачихна гэж ойлгохгүй байна. Нэг сонсгол хийгээд ахиад асуудал гарахгүй гэж ойлгохгүй байна. Тэгээд энэ асуудлын чинь объект, хүрээ нь одоо үнэхээр хил хязгааргүй л асуудал байна л даа. Тэгэхээр энэ чинь барьцгүй, гараад дүгнэлт нь тодорхой бус гарна, үр дүнгүй сонсгол болно. Одоо сонсгол хийхээр чинь энэ чинь төсөв мөнгө

шаардлагатай болдог. Дор хаяж 100, 200 сая төгрөг хэрэгтэй болдог, цаг хугацаа хэрэгтэй болдог, 9 сарын 10 гэдэг хугацаа бол амжихгүй асуудал. Хүний эрхийн асуудлаар тэгээд бүх чиглэлээр л хүний эрхийн асуудлаар өнөөдөр төлөв байдал ямар вэ гэдэг асуудлыг л ярих болох гэж байна шүү дээ энэ асуудлаар чинь бол. Би бол энийг чинь анх тэр залуугийн үүссэн асуудалтай холбогдуулж л сонсгол хийх юм байна гэсэн ерөнхий ойлголттой явж байсан.

Гэтэл энэ чинь асуудал чинь хүрээгээ, хязгаараа тэлээд ерөөсөө энэ хүний эрх, эрх чөлөөний асуудал гээд хэвлэн нийтлэх эрх чөлөө, тэр сэтгүүлчдийн эрх зүйн эрх чөлөөний асуудал гээд бүүр маш том асуудлууд болж ирж байна шүү дээ. Тэгэхээр энэ бол нэг өдөр ярилцаад ч амжихгүй асуудал. Тэгэхээр ер нь зүгээр хийхийн тулд хийсэн биш зүгээр энэ асуудлаа тодорхой үр дүнд хүргэе гэвэл энэ хил хязгаарыг нь хумьж, яг тэр кэйс дээрээ тулгуурлаж, асуудлаа ярьж явна гэвэл гарах үр дүн нь тодорхой болох байх. Тэрнээс өнөөдрийн энэ байгаагаар орж ирснээр, тогтоолын төслөөр орж ирснээсээ ингэж яривал бид нар энэ асуудлыг энэ сонсголоор ч битгий хэл цаашидаа энийг л хангуулахын төлөө үе үеийн төр засаг, Их Хурал явж байгаа шүү дээ. Энийг бид нар бүтэн хангаж чадахгүй шүү дээ. Тэгэхээр би бол үр дүн багатай сонсгол болчих юм болов уу гэсэн ийм ойлголттой байна.

Нөгөө талаар 9 сарын 10 гэдэг бол яг энэ тогтоолын төсөл энэ утгаараа явбал 9 сарын 10 яагаад ч хугацаа байхгүй. Нэг кэйс дээр тулгуурлаж явна гэвэл хамаа алга. Ийм саналтай байна.

Тийм учраас энэ хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой хяналтын сонсгол гэдэг энэ нэр томъёоны асуудал бол өргөн хүрээтэй байгаа учраас энийг жоохон хязгаарлах эрх, эрх чөлөөний асуудал яг сэтгүүлчдийн асуудлыг ярих гээд байгаа

юм уу, эсвэл цэрэгт явсан, эсвэл хоригдож байгаа, шүүхийн шийдвэргүйгээр хоригдож байгаа ч гэдэг юм уу ийм тодорхой кэйсүүд дээр тулгуурлаж асуудлаа яривал илүү үр дүнтэй, барьцтай болох юм болов уу л гэж ингэж бодож байна.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүнтэй бас санал нэг байна. Түрүүний гишүүдтэй л би яг адилхан байр суурьтай байгаа. Тэгээд би өөрийнхөө зүгээс хэдэн зүйл хэлчихмээр байна.

Нэгдүгээрт, энд манай Ардчилсан намын гишүүд маань энийг бас анхаараад үзнэ биз. Яагаад гэхлээр ийм чухал асуудал дээр энэ чинь оруулж ирж байж дандаа Ардчилсан намын гишүүд зурж байгаад оруулж ирсэн байдалтай. Нэг. Миний хувьд бол би хүний эрхийн асуудлыг бүүр ингээд эхнээс нь тултал дэмжиж байгаа.

Жишээлбэл, яг энэ асуудал гарахад Нараа гишүүн, Тэмүүжин гишүүн 2 санаж байгаа байх. Би өөрөө Архангайд шүүх, цагдаагийн ажилтай танилцаад явж байсан. Утас холбоо орж ирээд л би иүүд наашаа утасдаад энэ хурлыг нь хийхийг зөвшөөр өө, энэ чинь Байнгын хорооны зөвшөөрлөөр дэд хороо хуралдах зөвшөөрөл гарна шүү дээ. Тэгээд би энэ асуудлын даргын дэргэдэх зөвлөл рүү хөдөө явж байхдаа тавьж өгөөд, энэ асуудал даргын дэргэдэх зөвлөлөөр Улсын Их Хурлын дарга дэмжээд ингээд орж ирсэн. Энэ дээр ямар нэгэн саад бэрхшээлгүй энэ бүгдийг хийж байгаа.

Иймэрхүү хүний эрхийн асуудлыг бид нар улс төржүүлж болохгүй. Энэ ямар нэгэн, аль нэг намын хүний эрхийн асуудал гэж байхгүй. Монгол хүний л эрхийн асуудал Үндсэн хуульд заасан 16 дээр. Тэгэхлээр энэ дээр ер нь бас цаашдаа бүх намаасаа энэ ХҮН намаас ч гэсэн оруулж байгаад энэ санаачилга юмнуудаа гаргаж байх нь зөв байх.

Нэг үнэхээр ноцтой асуудал бол энд үнэхээр өргөн тавигдсан байна. Энэ саяын Сандаг-Очир гишүүний хэлж байгаа бол яг үнэн шүү. Энэ Их Хурлын хамгийн гол функцүүдийн нэг. Энэ чинь Үндсэн хуульд бүхэл бүтэн нэг тодорхой хэсэг энэ дээр зориулагдчихсан Үндсэн хуулийн эрх зүйн асуудал яригдаж байгаа байхгүй юу. Тэгэхлээр энэ дээр ийм өргөн хүрээгээр ярих юм бол Монгол Улс бид нарын ерөөсөө 4 жилийн ажилд тэр 16-д заасан хүний эрхийг л хэрэгжүүлэх тухай асуудал шүү дээ. Гол л асуудлуудын нэг. Улс орныг хөгжүүлэх гээд байгаа чинь эдийн засгийн эрх чөлөөг хангаж өгөх гээд л байгаа. Ажилтай байх эрх гээд л ингээд л цаашаа явж өгнө шүү дээ.

Тэгэхлээр энэ Үндсэн хуулийн энэ заалтыг энд ингээд дурдаад ийм өргөнөөр оруулаад ирнэ гээд 4 жилийн ажлыг одоо ингээд бид нар цаг хугацаанд яалт ч үгүй 30 хоногийн дотор хийх ёстой. Өнөөдөр бид нар энэ хурлаараа товыг нь зарлаж өгөөд 30 хоногийн дотор энийг нь хийхгүй бол болохгүй. Хууль нь ингээд заагдчихсан байж байгаа байхгүй юу. Тэгэхлээр энийгээ тал талдаа бодох хэрэгтэй байх.

Би өөрийнхөө зүгээс нэг зүйлийг л харин бодож байна. Энэ ингээд тогтоолын төслийг хэдүүлээ батлаад, дараа нь санаачлагчидтайгаа сууж байгаад энэ сонсголыг даргалах хүнтэйгээ сууж байгаад хүрээ хязгаарыг нь тохирч авах нь зөв байх гэж бодож байна. Тэгэхгүй бол энэ үнэхээр үр дүнгүй болно хамгийн гол нь. Тэгээд баахан хүн цуглуулаад энд тэндээс аваад тэгээд үр дүнгүй зүгээр яриа хийх бас Улсын Их Хурлын ажил биш.

Тэгэхлээр би тэр өнцгөөс нь саяын хэлсэн бүх гишүүдийн хүсэлтийг би нэгтгээд энэ чинь ингээд Байнгын хороо хуралдахад бүгд яг нэг жигд нэг л асуудал ярилаа шүү дээ энэ чинь аягүй өргөн болчихож байна аа гээд. Тэгэхлээр энийгээ нарийсгаж, ялангуяа тэр энэ асуудал үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн гол асуудал байсан бэ? Тэгээд тэр дээрээ тэгвэл илүү

төвлөрөөд явбал өгөөжтэй байх болов уу гэж бодож байна.

Ингээд Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Өмнөх сонсголдуудын тогтоолын төсөл яаж гардаг байсан юм гээд би бас мэдэхгүй болоод тэгж байгаа юм шүү. Энэ бол ингээд хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой асуудал гээд ерөнхий сонсгол хийх гарчиг байгаа байхгүй юу. Тогтоолын төсөл дээр энэ гарчгийг хяналтын хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой хяналтын сонсголыг тийм сэдвээр 24 оны тэдэн сарын тэдний тэдний өдөр гэж бичдэг тийм техник байхгүй юм уу? Тэгэхгүй бол энэ яаж байна вэ гэхээр хууль дээр байж байгаа сонсгол хийх төрлүүд байгаа байхгүй юу. Төрлийн нэг гарчгийг тавьчихаад байна биднүүс. Энэ төрлөөр тийм сэдвээр сонсгол хий гэж бичих ёстой юм биш үү? Асуудлаа тавиагүй учраас ингээд тавьчихсан юм юм уу?

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүн ээ энэ хуулийн сонсголын энэ хуулийн цаад эрх зүйн агуулга санаа гэхлээр гишүүн тодорхой асуудлаар өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд асуудлаа томъёолоод ороод ирэнгүүт жишээлбэл эрх барьж байгаа тоглогчид, тал энийг нь өөрчлөд байх боломжийг л хязгаарлаж өгч тавьж байгаа байхгүй юу. Тэгэхлээр энэ дээр надаа үлдэж байгаа хувилбар бол наадах чинь энүүгээрээ явбал ерөөсөө бүүр ингээд 4 жилийн ажил болно. Тийм учраас хурал даргалах хүнтэйгээ нийлж байгаад ядаад энэ удаадаа бол, гэхдээ энэ цаашидаа яах аргагүй бодох асуудал юм байна. Яах аргагүй.

Яагаад гэвэл мэдэхгүй хүмүүс маань мэдэхгүй биш, туршилага дутаад ийм өргөн хүрээнд оруулаад ирж байгаа тохиолдолд нөгөө хуулийнхаа цаад шаардлагыг биелүүлээгүй гэх хэцүү шүү дээ. Бас яг энийг хүссэн ч юм билүү айн? Тийм тэгье. Эрдэнэболд гишүүн үг хэлье

гэж байна. Би танд үг өгчихье. Эрдэнэболд гишүүний микрофоныг.

С.Эрдэнэболд: Тийм сүүлд нэр авсны дараа нэгтгэе гээд. Би бол ингэж бодож байна. Одоо та бол яг хуулиа баримталсан гээд ярьж байгаа шүү дээ тээ. Энэ зөв байх. Гэхдээ яахын аргагүй энэ чинь том сэдэв учраас аягүй үр дүнгүй, фокусгүй болчихно. Тэгээд хавийн юмнууд ярьдаг, тэгээд яг үүгээр нь бол улс төржилт маш их явчихна. Тэгэхээр энэ ийм байгаа юм. Ингээд өмнөх, та эзгүй байхад бид нар дэд хорооны хурал хийлээ шүү дээ. Биш ээ Хүний эрхийн. Энэ Хүний эрхийн дэд хорооны хурал хийнгүүт Тэмүүжин гишүүн хамгийн ахмад гээд ахлахгүй юу. Тэгээд тэнд чинь 2, 3 цагийн арга хэмжээ болсон юм. Бараг 4 цаг ч билүү, 5 цаг болсон уу? Их удсан юм байна. Тэгсэн чинь хамгийн сүүлд нь яасан бэ гэхлээрээ 21 хоногийн хугацаатай даалгавар өгсөн юм тэр хурал дээ. Тэгээд тэрнээс хойш яг 21 хоногийн хугацаанд гээд нийтдээ 7 төрлийн, үндсэн 5 дээр нэмэх нь 2, нийт 7 төрлийн ийм даалгавар өгөхгүй юу. Яагаад гэхлээр тэнд ирсэн 5 байгууллагын 18 албан тушаалтан ирээд, тэгээд хоорондох мэдээллүүд нь зөрүүтэй байсан.

Хоёрдугаарт, яг энэ 21 настай хүүхдийн амь насаа алдсан энэ хэрэг явдал дээр сонсгол зохион байгуулах асар ээдрээтэй юм байна лээ. Яагаад гэхлээр тэр чинь дундуур нь хаалттай горим дотор тухайн хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой юмнууд ярилцсан байхгүй юу. Тэгэхээр чинь сонсгол зохион байгуулна гэхээр чинь тэр асуудлыг яах вэ гэдэг асуулт үүснэ. Тэр чинь яг бодит байдлын нэг тал нь шүү дээ. Тэр бодит байдлын буюу тэр нууцын зэрэгтэй асуудлыг олон нийт мэдэх нь өөрөө аягүй хэцүү байхгүй юу бас. Хувь хүндээ хэцүү, хохирогчдоо хэцүү эд нар гээд үүсэж байгаа. Тэгэхлээр яг энэ, тийм тийм. Тэгэхээр яг энэ 21 настай хүүхдийн асуудал дээр сонсгол зохион байгуулна гэдэг бол аягүй их тийм хэцүү асуудал болчихоод байгаа байхгүй юу.

Гэтэл тухайн үеийн нийгмийн нөхцөл байдал, сошиал медиагийн хандлага бол яг тэр хэрэг дээр үндэслэж энэ юу чинь бий болоод, энэ дэд хорооны хурал болоод эндээс үндэслэж энэ бичиг гарч ирж байгаа байхгүй юу. Ер нь бол тухайн үеийн санаа бол. Тэгэхээр яг уг асуудал дээр нь хяналтын сонсгол эд нар хийнэ гэхээр дахиад нууцын зэрэгтэй асуудлууд чинь яах вэ гэдэг асуулт. Тэрийг бүтнээр нь хараагүй хүнд бол нийгэмд нэг тал нь харагдаад байгаа учраас өө энэ эд нар буруу гээд. Яах вэ тэр нь байсан. Нэг бол энэ ийм байгаад байгаа.

Тэгэхээр яг энэ дотроос бүгдээрээ ярьж байна шүү дээ нэг асуудал дээр гэхлээр хамгийн эхний сонсголыг нь тэр 21 настай хүүхдийн кэйс дээр хийчих гэхлээр бас өөрөө их асуудалтай болчихоод байгаа юм. Тэгэхлээр яг аль ерөнхий санаачилсан хүмүүстэйгээ ярьж байгаа та энэ тэгэхдээ хойшлуулж болно шүү дээ тээ? Яг хүний эрхийн асуудал гэхээд. Миний санаа болохоор ийм бодолтой байгаа юм. Манайд чинь дэд хороо гээд 10 хүн байгаа тээ Хүний эрхийн дэд хороон дээр? Аан тийм, энэ Хүний эрхийн дэд хороо ажлаа хийх ёстой юм биш үү? Хүний эрхийн дэд хороо чинь тэр 21 .../минут дуусав./

Д.Цогтбаатар: Микрофоноо дахиад гүйцээгээд өгье Эрдэнэболд гишүүний.

С.Эрдэнэболд: Тэгэхээр энэ ядаж энэ шинээр сонгогдсон гишүүдэд тэр Хүний эрхийн дэд хороо хийх ёстой вэ гэдэг дээр угаасаа мэдээлжүүлээд, тэгээд ийм ийм асуудал дээр Хүний эрхийн дэд хороо ингэж ингэж ажиллана гээд. Тэгээд Хүний эрхийн дэд хорооноосоо 21 хоногийн хугацаа одоо болж байгаа байх тээ? Бараг дөхөж байгаа шүү дээ. Тийм. Тэгээд тэр мэдээллүүдээ аваад, тэрний үндсэн дээр энэ сонсголтой холбоотой шийдлүүд яривал яасан юм? Тэгэхгүй болохлоор хоёр давхцаад байгаа юм биш үү тээ?

Нэг талд нь Хүний эрхийн дэд хороо яваад л байдаг. Нөгөө талд нь баахан сонсгол зохион байгуулна гээд л байдаг.

Д.Цогтбаатар: Хүний эрхийн дэд хорооны ажил бол угаасаа нэгэнт би ингээд хуралдуулаад л эхлүүлээд явуулчихсан бол одоо энэ чинь үүрэг, даалгавар зогсоогүй явж байгаа шүү дээ. Харин энийгээ өөрсдөө хурлаа хийчхээд, өөрсдөө Хүний эрхийн дэд хороо байж байж дахиад ингээд энэ чинь өөрөө тусдаа автономи процедуртай юм эхлүүлчхээж байгаа байхгүй юу. Одоо Эрдэнэболд гишүүнээ нэг аюултай юм нь энэ дээр би ямар нэгэн юу гаргаад энийг зогсоох юм руу орох юм бол наадах чинь аягүй том улс төрийн асуудал гараад ирж байгаа байхгүй юу. Нэг. Бид зогсоогоод хийх гэсэн юмыг зогсоогоод байгаа юм шиг. Тэгээд энэ чинь миний хэлээд байгаа нь яг нэг намын гишүүд дангаараа зурчихсан байгаад байна шүү дээ. Одоо зогсоохлоор чинь улс төр болчих байхгүй юу. Тэгээд одоо процедураараа явахаас өөр гарцгүй. Тийм. Тэр дээр нь би өөрөө санал тавина. Тийм, тийм.

Үгүй, үгүй. Нөгөөдүүлтэйгээ ярихгүй бол мань хүн тэд нарыгаа дангаараа одоо энд сууж байгаа төлөөлнө. Хэдүүлээ эрх зүйн эрсдэл өөрс дээрээ аваад хэрэггүй. Одоо явж байгаа процедур нь.

Ийм байна Сайнзориг дарга аа одоо би энийг ингэж буцааж харин болохгүй болчихоод байна шүү дээ. Тийм, би энэ хуулийн хугацаанд баригдчихсан энэ хамгийн сүүлийн өдөр нь бүр. Тэгэхлээр энийг хэдүүлээ энэ шийдвэрээ гаргая. Эрдэнэболд гишүүний ярьж, та нэгэнт өөрөө бас энийг санаачилчихсан хүмүүс учраас тэд нартай нь уулзаад хэдүүлээ яриад тэгээд аль болох хүрээ хязгаараа тогтоохыг бодъё. Тэр хүүхдийн асуудал дээр ч гэсэн арай, хэлэлцэж болно болно.

Гэхдээ хаалттай байхыг нь хаалттай байлгаад л яг та нар хийсэн

шигээ хийж болно шүү дээ. Зүгээр л нэг явж байгаа юмыг бид нар шал өөр, тэгсэн мөртөө энэ сонсгол чинь Их Хурлын дэд хороо гэдэг бол байнгын ажиллагаатай институт байхгүй юу. Энэ ажлаа хийж байхад тэрнээс хүчтэй механизмыг бид нар авчраад ажиллуулчихсан байж байгаа байхгүй юу. Тэгээд л энэ дээр ялангуяа гишүүний санаачилгыг ингэж ямар нэгэн байдлаар өөрчилж болохгүй ийм прецедент тогтоож ч болохгүй. Ийм байна.

Хэдүүлээ тэгэхлээр энэ дээр юу ч гэсэн яагаад, миний зүгээс та хэдийн ярьж байгаа саналыг би 100 хувь дэмжиж хүлээж авч байна. Эргэж ярьж байгаад гишүүдтэй өөрсөдтэй нь ярьж байгаад хэмжээг нь хязгаарлах гээд л үзье тэгэх үү?

За тэгье. Ингээд үг хэлж дууслаа.

Тогтоолын төслийг би танилцуулъя. Түрүүн Тэмүүжин гишүүн чухал асуулт асууж байна лээ. Энэ цэг дээр хэн байна вэ гээд. Би хууль зүйн чиглэлээрээ үнэхээр туршлагатай олон жил ажилласан Сайнзориг гишүүнийг удирдаад, даргалаад яваасай гэж хүсэж байгаа юм. Ингээд би тогтоолынхоо төслийг та бүгдэд танилцуулъя.

Төсөл, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол

“Хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1, 121.13 дахь хэсэг, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн мөн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой хяналтын сонсголыг 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулахаар тогтсугай.

2.Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой хяналтын сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийг сонгосугай.

3.Хяналтын сонсголын зарыг нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг хангаж, холбогдох хууль, журамд заасны дагуу зохион байгуулахыг Улсын Их Хурлын Тамгын газар Б.Баасандорж даргад даалгасугай.

Хуул зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар гэсэн байна.

Ингээд тогтоолын төслөө дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Нараа гишүүний микрофоныг өгье.

Нарантуяа-Нара: Юуны түрүүнд яагаад татгалзсан бэ гэхээр энэ 9 дүгээр сарын 10-ны өдөр энэ цаг хугацаа нь дэндүү давчуу байна гэж бодож байгаа. Тэгэхээс хурал даргалах энэ бусад зохион байгуулалтын ажил бол хэн байх нь, хамгийн гол нь энэ, заавал уу? Ямар сонин юм бэ тээ?

Д.Цогтбаатар: Нара гишүүн ээ одоо...энэ хуулийг та эсэргүүцээд санал өгчихлөө. Наадах чинь хуулийн заалт байхгүй юу.

Нарантуяа-Нара: Тэгвэл зөвшөөрсөн рүүгээ л орох юм байна.

Д.Цогтбаатар: Тэгэхээс. Номинчимэг гишүүн. Номинчимэг гишүүн саналаа гаргачихъя. Хуулиа дагахаас өөр үг үгүй энэ удаадаа бол тийм. Номинчимэг гишүүн горимын санал гаргачих.

О.Номинчимэг: Горимын санал гаргая. Би сая төхөөрөмж маань жоохон удаад, хугацаа хоцорсноос болоод ингээд татгалзсан дээр орсон. Тэгэхээр энэ санал хураалтыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулж өгөхийг хүсье.

Д.Цогтбаатар: Энэ саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Ингээд түрүүн уншиж танилцуулсан томъёоллоор санал хураалтыг дэмжье.

Өөрөөр хэлбэл, тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Сайнзориг гишүүн микрофонд саналаа дэмжсэн гэдгээ хэлчих. Тэгээд би бас саналыг тооцъё. Эрдэнэболд гишүүн бас тэгвэл та хоёр хоёулаа хэлчих тэгээд тооцчихъё.

П.Сайнзориг: Миний энэ төхөөрөмж болсонгүй. Би өөрөө энэ тогтоолыг хууль тогтоомжид нэгэнт заачихсан учраас дэмжиж санал өгч байгаа. Намайг дэмжсэн санал өгсөнд тооцож өгнө үү. Тэгвэл горимын санал гаргаж байна. Дахин санал хурааж өгнө үү төхөөрөмж ажиллахгүй байна дарга.

Д.Цогтбаатар: Тэгвэл саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Төхөөрөмж маань гацаад гарын хуруу уншихгүй байна. Тэгэхээр энэ санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү.

Д.Цогтбаатар: Тэгвэл энийг ингээд хүчингүй болгоё гэдгийг гараар санал хураалт явуулъя. Тэгэхлээр гараар санал хураалт явуулъя гэдгээ бас бид нар санал хураана биз дээ? Тэгж байж, тийм тэгвэл гараар санал хураах гэсэн саналаар санал хураах.

Ингээд 100 хувийн саналаар гараар санал хураах болж байна. 12-оос 8 гэдэг чинь хэд болж байна? Тийм 12-оос 8 гишүүн дэмжсэнээр гараар санал хураах горимын санал дэмжигдлээ. Ингээд 66 хувиар.

Одоо түрүүний уншиж танилцуулсан тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг гараар явуулъя.

Ингээд 12-оос 8 гишүүний саналаар тогтоолын төсөл дэмжигдлээ.

Хуралд оролцсон Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

Хэлэлцэх асуудал хэлэлцэж дууссан тул өнөөдрийн Байнгын хорооны хурал тарлаа. Баярлалаа.

16.27 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР